



45

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2010 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 23а

Улаанбаатар хот

Судалгааны ажил зохион байгуулах тухай

Монгол Улсын "Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль"-ийн 17 дугаар зүйл, тус газрын "Дүрэм"-ийн 4.2-ын заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. Улаанбаатар хотын нүүдэллэж суурьшиж байсан 25 газрыг судлан, "Хүрээ нүүдэл" хөтөлбөрийн хүрээнд аялалын маршрут болгох, хот орчмын хөшөө, түүхэн дурсгалт газрын ашиглалт, хамгаалалтын үйл явцтай танилцан нийслэлийн түүхийг олон нийтэд сурталчлан таниулах зорилготойгоор судалгааны ажил зохион байгуулан, дүн мэдээг 2011 оны 2-р улиралд багтаан тайлагнаж ажиллахыг хотын аялал жуулчлал хариуцсан ахлах мэргэжилтэн /Г.Баясгалан/-д даалгасугай.

Хоёр. Судалгааны ажил хийх үед зарцуулагдах шатахууны үнийг зохих журмын дагуу гэрээ байгуулан, тээвэр шатахууны зардлаас тооцон гаргахыг ахлах ня-бо /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ш.СҮХБААТАР